



МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 18 өдөр

№ 24/67

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 2 хэсэг, 65 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдаж, 2021 оны 45 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 2, 9 дүгээр зүйлийн 7.11, 7.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 16/22 дугаартай тогтоолоор батлагдаж, 2021 оны 21/08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт компанийн боловсруулсан мэдээллийн технологи, программ хангамжийг ашиглан цахимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
 1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
 3. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
 4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай тогтоолыг хүчингүй болгох тухай;
 5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
 7. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр болон мөн оны 4 дүгээр сарын 08-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сонин, компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2024 оны 3 дугаар

- сарын 27-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-г томилсугай.
 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Болортuya, "МИК ОССК" ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал;

Гишүүн: М.Буяндалай, "МИК ОССК" ХХК-ийн СУГ-Актив, пассив удирдлагын хэлтэст Санхүүгийн ахлах шинжээч;

Гишүүн: Б.Тулга, "МИК ОССК" ХХК-ийн МТГ-Программ хөгжүүлэлтийн хэлтэст програмрист.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр "Санал авах хуудас"-ны загварыг Хавсралт 4, 5, 6, 7, 8-р тус тус баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албандаа, хурлаар шийдвэрлэх асуудалд өгсөн саналыг 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цаг хүртэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот хаягт байрлах компанийн байранд хүлээн авах болон түүнтэй бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисст тус тус үүрэг болгосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.

ТОЛОӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТҮҮРГҮҮЛЭХИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,

